



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/01

Улаанбаатар
хот

**Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд
хийсэн дүгнэлтийг батлах**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах зөвлөлийн хийсэн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/02

Улаанбаатар
хот

Компанийн 2024 оны санхүүгийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.16 дах хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн 2024 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцүүлснийг хавсралтаар баталсугай.

2. 2024 оны санхүүгийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/, нягтлан бодогч С.Шижиртуяа нарт тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ”ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/03

Улаанбаатар
ХОТ

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.15, 77 дугаар зүйлийн 77.3, 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг, ердийн гишүүн болох Ц.Баатарсайхан, Д.Хулан, Ч.Ванчин-Эрдэнэ, Ц.Оюунцэцэг, Ц.Цэцэнхүү, Ц.Оргилболд, Хараат бус гишүүд болох Я.Пүрэвээ, Д.Байгальмаа, В.Хүрэлхад нарын бүрэн эрхийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр хугацаанаас нь өмнө дуусгавар болохыг баталсугай.

2. Энэхүү тогтоолыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болж буй гишүүдэд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Бат-Эрдэнэ/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг гарсан даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Улсын Бүртгэлийн Ерөнхий газарт тус тус холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА:



Ц.ОТГОНБАЯР



“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар ХЭХ03/04

Улаанбаатар
хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон Хараат бус гишүүдийг шинээр сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.15, 77 дугаар зүйлийн 77.1, 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

- 1) Ц.Баатарсайхан
- 2) Д.Хулан
- 3) Ц.Оюунцэцэг
- 4) Н.Мөнхбат
- 5) Ц.Отгонсүрэн
- 6) Э.Пүрэвлхам

2. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудалд хувьцаа эзэмшигчдийн олонхын санал авсан дараах нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

- 1) Д.Байгальмаа
- 2) Д.Болормаа
- 3) Д.Уянга

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд нь гишүүний үүргээ хууль болон компанийн дүрэмд нийцүүлэн хэрэгжүүлэх, компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж, шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг гарсан даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Улсын Бүртгэлийн Ерөнхий газарт тус тус холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Отгонбаяр/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: Ц.ОТГОНБАЯР

